



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯНХОНГОР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт



Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, бодлого, хяналт орон нутгийн түвшинд нэгдсэн байдлаар хэрэгжиж чадахгүй байна.

Баянхонгор хот

2016 он

Тайланг бэлтгэсэн:

**ҮАГ-ын харьяа Баянхонгор
аймгийн аудитын газар**

Газрын дарга:

Ё.Сугаррагчаа

Аудитын менежер:

Д.Цэцэгмаа

Ахлах аудитор:

Б.Мөнхбат

Аудитор:

Б.Азбаяр

М.Алтантуяа

Шинжээч: Б.Цэрэнчимэд

2016 оны 10 дүгээр сар

Уг тайланг ҮАГ-ын

Цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70442424
дугаарын утас, 70442584
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
харьяа Баянхонгор аймагийн
аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-64000
Монгол Улс

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

4

АУДИТЫН ДҮН

6

Зорилт 1. Аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

7

Зорилт 1.1: Аймаг, сумын ИТХ-аас байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсөв баталж, тогтоол гаргаж байгаа ч хэрэгжилтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна.

7

Зорилт 1.2 Аймаг, сумын Засаг дарга нар ИТХ-аас баталсан зарим тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

7

Зорилт 2. Ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой бус төлөвлөснөөс шалтгаалан төлөвлөгөө давж биелсэн ба түүнийг төсөвт бүрэн төвлөрүүлжээ.

10

Зорилт 2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос ан, агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт нь ангийн менежментийн төлөвлөлтийн хугацаанаас хамаарч бодитой бус болж байна.

10

Зорилт 2.2: Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөснөөс 2014 онд 100,6 сая, 2015 онд 83,8 сая төгрөгөөр дутуу, ан агнуурын нөөц ашигласны орлого төлөвлөснөөс 2014 онд 71,8 сая, 2015 онд 383,3 сая төгрөгөөр илүү орсон байна.

11

Зорилт 3: Зарим сумууд ан, агнуурын нөөц ашигласны орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заасан хувь хэмжээний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө хуваарилж зарцуулаагүй байна.

12

Зорилт 3.1: Сумын төсөвт төвлөрч байгаа байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд заасны дагуу мөрдөж ажиллахгүй байна.

12

Зорилт 3.2: Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулахаар төлөвлөсөн боловч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээнд бүрэн зарцуулагдаагүй байна.

14

Зорилт 3.3: Сумын төсөвт төвлөрсөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулаагүй байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журамтай нийцэхгүй байна.

15

Зорилт 3.4: Чандмань-Баянхонгор ХК-ийн ус ашигласны нөөцийн төлбөрийн орлогоос хөнгөлөлт, чөлөөлөлт хийхдээ БНАТХ-ийн 20.1.1 дэх заалтыг зөрчиж буруу тооцсон байна.

21

Зорилт 4: Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хуульд заасны дагуу дотоод хяналт хийх ёстой төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбооноос шалтгаалан хяналтын ажлын үр дүн хангалтгүй байна

22

Зорилт 4.1 Орон нутгийн түвшинд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчин байгаа боловч хяналтын тогтолцоо нь өөр өөр харьяаны агентлагуудад хуваагдсан байдалтай байна.

22

Зорилт 4.2 2014-2015 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд дотоод нэгжүүдээс хяналтыг хэрэгжүүлсэн боловч хангалтгүй байна.

23

АУДИТЫН ДҮГНЭЛТ

25

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуучлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИББЦХГЗ	Их Богдын байгалийн цогцолборт хамгааллын газрын захиргаа
БНАТХ	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХК	Хувьцаат компани
УЦУОША	Ус, цаг уур орчны шинжилгээний алба

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийв.

Аудитын зорилт.

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, сумын хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Аймаг, сумын ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх;
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудит хамарсан хүрээ.

Аймгийн БОАЖГ, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, аймаг сумын ИТХ, аймаг сумын Засаг дарга, аймгийн Татварын хэлтэс, холбогдох аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлав.

Аудитын арга зүй.

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа

болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Усны тухай хууль
- Амьтны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2016 оны 137 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

АУДИТЫН ДҮН

Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймаг нь газрын нөөц баялгаас гадна шилмүүст хар мод болон заган ой, ховор ан амьтан, ховор ургамлын нөөцтэй бөгөөд үүнээс ойн сан бүхий газар нутаг нь улсын тусгай хамгаалалтад ордог тул ойгоос мод бэлтгэх үйл ажиллагаа хуулиар хориотой байна. Ховор ургамлын хувьд Богд, Баацагаан суманд чихэр өвсний тодорхой хэмжээний нөөцтэй бөгөөд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас 2014, 2015 онд тус бүр 1500 кг-г бэлтгэх зөвшөөрөл олгосон боловч нутгийн иргэд, байгаль хамгаалах хөдөлгөөний эсэргүүцлийн улмаас чихэр өвс бэлтгэгдээгүй байна.

Ховор ан амьтныг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу тусгай хамгаалалттай бүс нутагт хамрагдаагүй газруудаас агнуулсан байна.

Аймгийн дүнгээр 2014 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 300,0 сая төгрөгөөр төлөвлөж 199,4 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 20,0 сая төгрөгөөр төлөвлөж 91,8 сая төгрөгийн орлого орсон байна.

2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөр 200,0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж, 116,2 сая төгрөгийг, ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс 30,0 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 413,3 сая төгрөгийн орлогыг тус тус оруулжээ. Үүнээс Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2014 онд 115,1 сая, 2015 онд 59,4 сая төгрөг төлөвлөж зарцуулсан байна.

Аудитад аймгийн Аудитын газрын холбогдох ажилтнуудаас гадна сумдад аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Наранбаатар, Э.Өнөрзаяа, МХГ-ын улсын байцаагч Б.Түмэнчимэг нар оролцож, 2014-2016 оны Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж шалгалаа.

Зорилт 1. Аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

Зорилт 1.1: Аймаг, сумын ИТХ-аас байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсөв баталж, тогтоол гаргаж байгаа ч хэрэгжилтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор байгаль хамгаалах арга хэмжээнд 2014 онд 115,1 сая, 2015 онд 54,9 сая, 2016 онд 104,5 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Аудитаар сумдын ИТХ хуульд заасан эрх үүргээ хэрхэн биелүүлж байгааг газар дээр нь шалгахад байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд төсөв батлаагүй, харин ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгдөөгүй орсон орлогоос тайлант оны дунд буюу эцэст төсөвт нэмэлт өөрчлөлт хийх байдлаар тодорхой хэмжээний хөрөнгийг баталж байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогогүй сумууд байгаль хамгаалах арга хэмжээнд хөрөнгө төлөвлөөгүй байна.

Аудитын явцад хийсэн судалгаанаас үзэхэд /хавсралт 01/ аймаг, сумын ИТХ Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу байгалийн баялгийг зохистой хамгаалах, нөхөн сэргээж арга хэмжээг хэрэгжүүлэх тогтоол гаргаж байгаа ч түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна.

Зорилт 1.2 Аймаг, сумын Засаг дарга нар ИТХ-аас баталсан зарим тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

Аймгийн Засаг дарга Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, 2014-2016 онд дээрх төсвийг батлуулсан байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан байгаль хамгаалах арга хэмжээг аймгийн БОАЖГ-ын дарга болон сумдын Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэх байдлаар зохион байгуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.2 “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ

боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах” гэж заасны дагуу “Рашаан ашигласны төлбөр тогтоох тухай” аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 99 тоот, “Ус ашиглалтын зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” 2014 оны 87, 121 тоот тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагууд зохион байгуулаагүйгээс аудитаар доорх зөрчил илэрлээ.

Үүнд:

1. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт рашаан, сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Шаргалжуут рашаан сувилал” ХХК-ийн 2015 оны ус ашиглах дүгнэлтийг “Монгол ус” ТӨҮГ 2015.12.22-нд гаргасан, 2016 оны ус ашиглах дүгнэлт 2016.09.28-ний байдлаар гараагүй, ус рашаан ашигласны нөөцийн төлбөрийн ногдуулалт хийгдээгүй.
2. Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт 2014 оноос хойш рашаан, сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Баян-Зэндмэнь ундарга” ХХК-ийн Бага шаргалжуут рашаан сувилал нь 2014 онд ус ашиглах дүгнэлт гаргуулсан боловч ус, рашаан ашигласны төлбөрийг төлөөгүй, 2015, 2016 онд ус ашиглах дүгнэлт гаргуулаагүйгээс ногдуулалт хийгдээгүй, рашаан, ус ашигласны төлбөр төлөгдөөгүй байна.

Дээрх зөрчлийн шалтгааны талаар аймгийн БОАЖГ, МХГ, Татварын хэлтэс, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнүүдээс тодруулга авлаа. Үүнд:

- Аймгийн МХГ-ын байгаль орчны улсын байцаагч манай байгууллага дээрх газруудад сүүлийн 3 жилд байгалийн нөөц ашиглалтад шалгалт хийгээгүй,
- Татварын хэлтсийн орлогын тасгийн дарга холбогдох газрууд нь усны дүгнэлтээ гаргаж ногдуулалт хийгээгүй тул бид хураалт хийх эрхгүй, 2014-2015 онд татварын хяналтын төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй тул нөхөн ногдуулалт хийх боломжгүй,
- БОАЖГ-ын мэргэжилтэн усны дүгнэлт гаргуулах албан тоот хүргүүлсэн, бид улсын байцаагчийн эрхгүй тул хариуцлага тооцож чаддаггүй,
- Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга 2016 оны 5-р сард газар дээр нь очиж хэмжилт хийсэн. Усны дүгнэлттэй холбоотой баримт бичиг

дутуу бүрдүүлснээс одоо болтол дүгнэлт гараагүй гэсэн тайлбарыг тус тус өгсөн болно.

Аудитын явцад холбогдох төрийн байгууллагуудыг тус тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсний дагуу Бөөнцагаан – Орог нуурын сав газрын захиргааны байгаль орчны хяналтын улсын байцаагч дээрх аж ахуйн нэгжүүд мэдээллээ ирүүлэхгүй байгаа тул Усны тухай хуулийн 33.1.13 дахь заалтын дагуу аж ахуйн нэгж тус бүрт 1924,0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан тухай шийтгэврийн хуудас, аймгийн Татварын хэлтсээс тус аж ахуйн нэгжүүдэд татвараа тайлант онд багтаан төсөвт төвлөрүүлэх шаардлага хүргүүлсэн тухай албан тоот ирүүллээ.

Иймд аймгийн ИТХ-ын 2013 оны 99 тоот “Рашааны үнэ тогтоох тухай” тогтоолыг нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгөв.

Усны тухай хуулийн 13.1.2-т “Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих” гэж заасан бүрэн эрхээ Өлзийт сумын Засаг дарга хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргаас 2014, 2015 онд хэрэгжүүлсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга хэмжээний биелэлтийг газар дээр нь очиж шалгахад дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Богд суманд байгуулсан мод үржүүлгийн газрын усалгаа арчилгаа хангалтгүй, хариуцсан ажилтан ажлын байран дээр байхгүй, суулгацыг он болон төрлөөр нь ангилж тариагүй.
- Булгийн эх хамгаалах арга хэмжээгээр хэрэгжүүлсэн зарим ажил газар нутгийн онцлогийг харгалзаагүйгээс хангалтгүй хийгдсэн. Тухайлбал: 2015 онд хийгдсэн Баянговь сумын Халзан булгийн хашааг тэмээ шөргөөсний улмаас нурж унасан.
- 2015 онд Өлзийт сумын Худаг-Уртын Бэлхийн булгийн эх хаших зориулалтаар авсан хөрөнгийг зориулалт бусаар ашиглан 4-р багийн төвийн барилгын хайс хийсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.
- Баян-өндөр сумын ЗДТГазар булгийн эх хашсан 2000,0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

Зарим сумдын Засаг дарга нар байгаль орчныг нөхөн сэргээх тухай сумын ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлэхдээ нөхөн сэргээлт хийх нэрээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан алт олборлолтын үйл ажиллагаа явуулж , аймаг орон нутгийн төсөвт

ямар нэг татвар төлөгдөхгүй, тухайн компаниуд нь байгаль орчны холбогдох хуулиудыг зөрчсөн үйл ажиллагаа явуулсаар байна. Үүнийг таслан зогсоох талаар аймгийн БОАЖГ-аас 2016.04.08-нд 114 тоот, МХГ-аас 2016.04.18-нд 4/110 албан бичгээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 7.3, Ашигт малтмалын тухай хуулийн 7.3, Газрын хэвлийн тухай хуулийн 7.1, 10.2, 31.1 дэх заалтуудыг зөрчиж байгаа тул хууль бус үйл ажиллагаагаа зогсоох эс биелүүлбэл холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт мэдэгдсэн байхад үйл ажиллагаагаа зогсоогоогүй байна.

Тухайлбал: Өлзийт, Жаргалант, Баян-Овоо, Заг, Галуут, Бөмбөгөр зэрэг сумууд нөхөн сэргээлт нэрээр алт олборлох үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ зохион байгуулсаар байна.

Зорилт 2. Ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой бус төлөвлөснөөс шалтгаалан төлөвлөгөө давж биелсэн ба түүнийг төсөвт бүрэн төвлөрүүлжээ.

Зорилт 2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос ан, агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт нь ангийн менежментийн төлөвлөлтийн хугацаанаас хамаарч бодитой бус болж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хэрхэн төлөвлөж байгаа талаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс баримт материал авч судалж үзэхэд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөдөг, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яам сууриар тооцон төлөвлөгөөнд тусган өгдөг байна.

Он /сая.төг/	Уулын ажлын төлөвлөгөө болон ус ашиглах дүгнэлтээр	Орон нутгийн татварын /ус, рашааны төлбөрийн орлого/ төлөвлөлт	Усны төлбөрийн орлогын төлөлт
2014	593.2	300.0	199.2
2015	458.3	200.0	116.2
Grand Total	1,051.5	500.0	315.4

Дээрх хүснэгтээс үзэхэд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг уулын ажлын төлөвлөгөө болон усны дүгнэлтээр гаргасан дүн нь өндөр байгаа бөгөөд үүнийг бууруулан төлөвлөсөн боловч төлөвлөгөө биелээгүй байна.

Ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг аймгийн Санхүү, төрийн сангийн болон аймгийн Татварын хэлтсийн мэргэжилтнүүдээс тодруулахад уул уурхайн компаниуд тухайн жилд ашиглахаар тооцсон уулын ажлын төлөвлөгөөнд хүрч ажиллаж чаддаггүй, зарим компаниуд усны дүгнэлт гаргуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүйгээс шалтгаалан төлөвлөлтийг бууруулж хийсэн болно гэсэн тайлбар өглөө.

Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөхгүй байгаа шалтгааныг төсвийн мэргэжилтнээс тодруулахад төсвийн төсөл хэлэлцэх хуулийн хугацаанд багтаж ангийн менежментийн төлөвлөгөө батлагдаагүй байдаг ба энэ орлого нь тодорхойгүй учир төлөвлөдөггүй гэсэн тайлбарыг өгсөн болно.

Аудитын явцад сумдад ажиллаж байхад сумдын Засаг дарга нар ан, агнуурын нөөц ашигласны орлогыг урьдчилан төлөвлөх бололцоогүй, дараа жил ямар анг, хаанаас, хэдий хэмжээгээр агнах нь тодорхойгүй гэсэн тайлбарыг өгч байсан нь дээрх мэдээллийг баталж байна.

Дээрх байдлаас үзэхэд ан, агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой бус хийгддэг нь тухайн суманд төлөвлөгдөөгүй гэнэтийн орлого орох шалтгаан болж байна.

Зорилт 2.2: Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөснөөс 2014 онд 100,8 сая, 2015 онд 83,8 сая төгрөгөөр дутуу, ан агнуурын нөөц ашигласны орлого төлөвлөснөөс 2014 онд 90,4 сая, 2015 онд 383,3 сая төгрөгөөр илүү орсон байна.

Аймгийн дүнгээр 2014 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс орох орлогыг 300,0 сая төгрөгөөр төлөвлөж 199,2 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 20,0 сая төгрөгөөр төлөвлөж 110,4 сая төгрөгийн орлого тус тус орсон.

2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөр 200,0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж, 116,2 сая төгрөгийг, ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс 30,0 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 413,3 сая төгрөгийн орлогыг тус тус оруулжээ.

Ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө дээрх онуудад тасарсан нь уул уурхайн аж ахуйн нэгжүүд уулын ажлын төлөвлөгөөний дагуу бүрэн ажиллаагүй,

мөн цооногууд дээр усны тоолуур байрлуулан нуур үүсгэж усаа дахин ашиглах байдлаар усны хэрэглээг багасгаснаас шалтгаалжээ.

Ан, агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого нь төлөвлөгөөнөөс давж биелсэн нь төлөвлөлттэй холбоотой бөгөөд орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны орлогын төвлөрүүлэлтийг холбогдох баримт бичигтэй /гэрээ, зөвшөөрөл, акт/ тулган шалгахад доорхи зөрчлүүд илэрлээ.

Үүнд:

- Ус ашиглалтын төлбөрийн орлогоос Шинэжинст сум 2,2 сая төгрөг, Хүрээмарал сум 410,9 мянган төгрөг, Өлзийт сум 2,0 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлэн зарцуулсан.
- Өлзийт сум уул уурхайн нөхөн сэргээлтийн орлого 15,0 сая төгрөгийг төсөвт байгууллагын харилцах дансанд тушаалгүй сумын ЗДТГ-ын няравт бэлэн орлого авсныг аудитын явцад төлбөрийн акт тогтоон орон нутгийн татварын орлогын дансанд тушаалгав.

Зорилт 3: *Зарим сумууд ан, агнуурын нөөц ашигласны орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заасан хувь хэмжээний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө хуваарилж зарцуулаагүй байна.*

Зорилт 3.1: *Сумын төсөвт төвлөрч байгаа байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд заасны дагуу мөрдөж ажиллахгүй байна.*

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу зарцуулж байгаа эсэхийг орлогын төрөл тус бүрээр нь аймаг, сумын татварын орлого, санхүүгийн тайлан мэдээ, ИТХ-ын тогтоолд үндэслэн шинжилгээ хийлээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Сумын төсөвт төвлөрүүлсэн байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогын нэгтгэсэн дүн

№	Төлбөрийн төрөл	2014				2015			
		Нийт орсон орлого /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтаар /хувь/	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтын хэрэгжилт /хувь/	Нийт орсон орлого /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтаар /хувь/	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтын хэрэгжилт /хувь/
1	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	110.4	50%	21.6	19.6%	413.3	50%	112.3	27.2%
2	Ус ашигласны төлбөр	0.8	35%	-	-	2.5	35%	-	-
		111.2		21.6	19.6%	415.8		-	27.2%

Аймгийн төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын дүн

№	Төлбөрийн төрөл	2014				2015			
		Нийт орсон орлого /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтаар /хувь/	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтын хэрэгжилт /хувь/	Нийт орсон орлого /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтаар /хувь/	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал /сая.төг/	БНАТХ 18.1 дэх заалтын хэрэгжилт /хувь/
1	Ус ашигласны төлбөр	198.4	35%	115.1	58.0%	113.7	35%	54.9	47.2%
		198.4		115.1	58.0%	113.7		-	47.2%


Дээрх судалгаанаас үзэхэд уул уурхай болон рашаан сувиллын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ус, рашаан ашигласны төлбөрийн орлого аймгийн төсөвт төвлөрч, түүнээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд заасан 35%-иас илүү буюу 2014 онд 58%, 2015 онд 47,2 %-ийг зарцуулсан байна.

Харин сумдын хувьд ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд 19,6%, 2015 онд 27,2%-ийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан нь БНАТХ-ийн 18.1-т заасан хувь хэмжээнд хүрэхгүй байна.

Зорилт 3.2: Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулахаар төлөвлөсөн боловч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээнд бүрэн зарцуулагдаагүй байна.

Аймгийн дүнгээр ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2014 онд 300,0 сая төгрөгөөр төлөвлөж 199,2 сая, 2015 онд 200,0 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс ус рашааны нөөц ашигласны төлбөрөөс 116,2 сая төгрөгийн орлого оруулжээ.

2014, 2015 онд ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын 50-иас дээш хувь нь уул уурхайн компаниудын ус ашиглалтаас орсон байна.



Аймгийн төсөвт төвлөрсөн ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос БНАТХ-ийн дагуу 35 хувь буюу 2014 онд 69,8 сая төгрөг зарцуулах ёстойгоос 115,1 сая төгрөгийг, 2015 онд 40,7 сая төгрөг зарцуулахаас 53,9 сая төгрөгийг байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан байна. Дээрх зарцуулалтыг зардлын нэр төрлөөр графикаар харуулбал:





2014 онд 17 хувь буюу 10 суманд усны ундарга, булаг шандны эхийг хамгаалахад 20,0 сая төгрөг, сурагчдад экологийн боловсрол олгоход 5,0 сая төгрөг, 2015 онд 40 хувь буюу аймгийн Засаг даргын захирамжаар усны тооллого явуулахад 20,0 сая, булгийн эх хамгаалахад 4 суманд 8,0 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу зарцуулжээ.

2014-2015 онд сумдын төсөвт орсон 3,4 сая төгрөгийг тус журмын дагуу зарцуулаагүй байна.

Усны тухай хуулийн 31.2. “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлөх бөгөөд шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэж заасан журам батлагдаагүйгээс илүү ашигласан усны төлбөрийг тооцохгүй боломжгүй байна.

Сумдын Засаг дарга нар Усны тухай хуулийн 13.1.1. “усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох”, 13.1.5. “энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгох” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс сумын ИТХ-аар усны үнэлгээ тогтоосон тогтоол гарсан байхад нэг ч аж ахуйн нэгж, албан газраас ус ашигласны төлбөр аваагүй байна.

Зорилт 3.3: Сумын төсөвт төвлөрсөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулаагүй байгаа нь

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журамтай нийцэхгүй байна.

Ургамал: Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас 2014, 2015 онд үйлдвэрлэлийн зориулалтаар ховор ургамал түүж бэлтгэх дээд хэмжээг тогтоож Баянхонгор аймгийн нутагт дэвсгэрээс 1500 кг чихэр өвс түүх зөвшөөрөл өгсөн байна.

Ховор ургамал болох чихэр өвсний тархац нь Богд, Баацагаан сумдын нутгаар тархалттай бөгөөд Богд сумын ИТХ-с 2006 онд чихэр өвс түүхийг хориглосон тогтоол гаргасан, Баацагаан сумын иргэд чихэр өвс түүлгэхийг эсэргүүцсэн тул тус онуудад чихэр өвс бэлтгээгүй байна.

Ан амьтан: БОНХЯ-ны сайдын 2014 оны А-128 тоот тушаалаар Монгол улсад тусгай зориулалтаар 2014 онд нийт 27 угалз агнуулахын 5 угалзыг, 40 тэх агнуулахын 10 тэхийг Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрээс агнуулах хуваарь гарсан байна.

Аудитаар Баянхонгор аймагт 2014 онд агнах зөвшөөрөлтэй 5-н угалзыг 100 хувь агнаж, 10 тэх агнуулах зөвшөөрөлтэй байхад 13 тэх агнуулж, зөвшөөрөгдсөн дүнгээс 3 тэх илүү агнуулсан болохыг тогтоолоо.



Галуут сум 2-ыг агнуулахаас 1 тэх дутуу агнуулж, тэх агнуулах хуваарьгүй байсан Баянбулаг сум 4 тэх агнуулж, нийт дүнгээрээ аймгийн хэмжээнд 3 тэх илүү агнуулсан байна.

Амьтны тухай хуулийн 37.4 “...гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, түүнчлэн зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49.4.2 “амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр” нөхөн төлбөр ногдуулна гэж заасан байхад Баянхонгор аймгийн нутаг

дэвсгэрт 2014 онд илүү агнуулсан 3 толгой тэхийн нөхөн төлбөрийн асуудал тодорхойгүй байх тул ҮАГ дээр нэгтгэгдэж байгаа аудитын судалгааны дүнтэй тулган шалгуулах хүсэлтийг тавьж байна.

2014 онд ан, агнуурын төлбөрөөр Өлзийт сум 32,7 сая, Баянцагаан сум 16,5 сая, Хүрээмарал сум 19,7 сая, Жинст 3,1 сая, Галуут сум 6,6 сая, Баянбулаг сум 15,7 сая, Богд сум 10,1 сая төгрөг, Заг сум нэг шонхор шувуу бариулсны төлбөрийн орлогоор 6,0 сая нийт 110.4 сая төгрөгийн орлого оруулжээ.

Зарим сумууд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг Татварын албанд буруу мэдээлсэн байна.

Тухайлбал: Заг сум шонхор шувуу бариулсны 6,4 сая төгрөгийн орлогын 0,4 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор, Хүрээмарал сум тэх агнуулсны төлбөрийн 19,7 сая төгрөгийн орлогоос 2,9 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор татварын тайланд мэдээлсэн байна.

Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 19,6% буюу 21,6 сая төгрөгийг Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4.2, 3.4.3-т заасны дагуу нөхөн сэргээлтэд 16,7 сая, байгаль хамгаалагчийн тоног төхөөрөмж худалдан авахад 350,0 мянган төгрөг, хяналтын шатахуунд 4,5 сая төгрөг зарцуулсан байна.

2015 онд Баянхонгор аймагт 2 толгой угалз агнуулах зөвшөөрөлтэйгөөс 100 хувь агнуулсан, 15 толгой тэх агнуулахаас 11 толгой тэх агнуулсан байна. Баянхонгор аймаг 2015 онд угалз агнуулсны 51,6 сая, тэх агнуулсны 56,1 сая нийт 107,7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан байна.

Баянбулаг сум 2015 онд ангийн орлогын 15,7 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор татварын тайланд мэдээлсэн байна.

Амьтны тухай хуулийн 26.1. “Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан **аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.**”, 26.2. “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно.” гэсэн заалтыг зөрчиж БОНХЯ-аас олгосон зөвшөөрөлд аймаг, сумдын нутгаас агнах агнуурын хэмжээг нарийвчлан тогтоож өгөөгүйгээс шалтгаалсан байна.

Мөн сумдын Засаг дарга нар амьтны тухай хуулийн 25.5. “Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 26.2-т заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгож болно.” гэсэн заалтын дагуу Өлзийт сумаас бусад нь гэрээ байгуулаагүй байна.

Аймгийн БОАЖГ Амьтны тухай хуулийн 5.8.1 “батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн

захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх”, 5.8.3 “энэ хуулийн 5.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэсэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

2015 онд ан, агнуурын нөөц ашигласны орлогоор 413,3 сая төгрөг орсноос 112,3 сая төгрөгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх дараах арга хэмжээнд зарцуулжээ. Үүнд:

- Байгаль хамгаалагчид тоног төхөөрөмж 60,8 сая
- Хог зайлуулах, дарах, хогийн цэг байгуулахад 30,0 сая
- Шатахуунд /хяналт шалгалтын ажлаар/ 3,2 сая
- Байгаль хамгаалагчийн урамшуулал 3,1 сая
- Усны өдөрлөг зохион байгуулахад 1,2 сая
- Түүх дурсгалын газар сэргээн наадам зохион байгуулахад 3,3 сая
- Нохой устгалд 2,2 сая
- Байгаль хамгаалагчийн мотоцикл 1,8 сая
- Ангийн отгын гэр 1,8 сая
- Булгийн эх хамгаалахад 4,9 сая

2016 онд Өлзийт сум 2 угалз агнуулж, 40,2 сая, Баянцагаан сум 1 угалз агнуулж 19,9 сая, Галуут сум 1 угалз агнуулж, 20,1 сая, Богд сум угалз агнуулах урьдчилгаанд 20,1 сая, Баацагаан сум 4 тэхийн 19,2 сая, Жинст сум 2 тэхийн 4,8 сая төг, нийт 124,3 сая төгрөгийн орлого тус тус орсон байна.

БНАТХ-ийн дагуу ан амьтан агнасны нөөцийн төлбөрийн орлогын 50%-г байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах заалттай байтал 2014 онд 55,2 сая төгрөг зарцуулахаас 21,6 сая төгрөгийг зориулалтын дагуу, 33,6 сая төгрөгийг зориулалт бусаар, 2015 онд 206,7 сая төгрөг зарцуулахаас 112,3 сая төгрөгийг зориулалтаар, 94,2 сая төгрөгийг зориулалт бусаар орон нутгийн төсвийн эх үүсвэрт тус тус зарцуулсан нь БНАТХ-ийн 18.1."Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын ажлаар БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Наранбаатар, аймгийн МХГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Түмэнчимэг нарыг татан оролцуулж, хангайн бүсийн 8 сумдаар ажилласан хугацаанд 16 ширхэг тарваганы түүхий мах, тулам хураан авч, ЭМС-ын 187 дугаар тушаалын дагуу халдваргүйтгэл хийж, устгалын акт бичиж устган, Зооноз өвчин судлалын төвийн лабораторд хүлээлгэн өгсөн болно. Дээрх зөрчилтэй холбогдуулан аймгийн МХГ-ын улсын байцаагч 1536,0 мянган төгрөгийн торгууль ногдуулав.



Зорилт 3.4: Чандмань-Баянхонгор ХК-ийн ус ашигласны нөөцийн төлбөрийн орлогоос хөнгөлөлт, чөлөөлөлт хийхдээ БНАТХ-ийн 20.1.1 дэх заалтыг зөрчиж буруу тооцсон байна.

БНАТХ-ийн 20.1.1. "хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах" заалтын дагуу хүн амын унд, ахуйн хэрэгцээнд нийлүүлсэн усыг төлбөрөөс чөлөөлж байгаа эсэхийг Чандмань-Баянхонгор ХК-ийн гаргуулсан усны дүгнэлт, татварын тайланд үндэслэн тулган шалгалт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Отгонбаяр Чандмань-Баянхонгор ХК-ний 2014, 2015 онд төсөвт байгууллагуудын хэрэглэх усны хэмжээг усны төлбөрөөс чөлөөлөхөөр, 2016 онд усны төлбөр төлөхөөр гэсэн 2 янзын дүгнэлт гаргасан нь БНАТХ-ийн 20.1.1-дэх заалттай нийцэхгүй байна.
- Чандмань Баянхонгор ХК ус ашиглалтын төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтийг татварын тайланд тусгаагүй, дутуу ногдуулалт хийж татварын тайланг буруу гаргасан.
- Аймгийн Татварын хэлтэс тайланг хүлээн авахдаа Татварын ерөнхий хуулийн 29.1.8. "татвар ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх, татвар хураахдаа Монгол Улсын татварын болон бусад хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх" гэсэн заалтын дагуу хяналт тавиагүй байна.

Иймд "Чандмань-Баянхонгор" ХК-ийн 2014, 2015 оны ногдуулалтад хяналт шалгалт хийх, 2016 оны ногдуулалтыг усны дүгнэлтийн дагуу тооцож Татварын

ерөнхий хуулийн 29.1.8 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Татварын хэлтэст өгөв.

Зорилт 4: Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хуульд заасны дагуу дотоод хяналт хийх ёстой төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбооноос шалтгаалан хяналтын ажлын үр дүн хангалтгүй байна.

Зорилт 4.1 Орон нутгийн түвшинд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчин байгаа боловч хяналтын тогтолцоо нь өөр өөр харьяаны агентлагуудад хуваагдсан байдалтай байна.

Орон нутгийн хувьд Байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих дараах эрх зүйн орчинг хуульд тусгасан байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.4 “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах,...” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга,
- Тус хуулийн 26.1-д “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу аймгийн МХГ
- Усны тухай хуулийн 13.1.2. “Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих” гэж заасны дагуу сумын Засаг дарга.
- Усны тухай хуулийн 17.1.10. “сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах” гэж заасны дагуу Бөөнцагаан-Орог нуурын сав газар.
- Усны тухай хуулийн 18.1.1. “усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах” гэж заасны дагуу аймгийн БОАЖГ хяналт тавихаар заасан байна.

Аймгийн БОАЖГ хяналт тавьж байгаа боловч хуулиар олгогдсон эрхийн дагуу байгаль орчны улсын байцаагч нь Шадар сайдын харьяаны агентлаг болох МХЕГ-т

харьяалагдаж байгаа тул БОАЖГ-ын хяналт тавих эрх нь хязгаарлагдмал, гарсан зөрчилд газар дээр нь хариуцлага тооцож арга хэмжээ авч чадахгүй байна. Мөн усны тухай хуулийн хэрэгжилтэд хуулиар БОАЖГ хяналт тавихаар заасан боловч Усны сав газар нь өөрийн нутаг дэвсгэрт харьяалагдаж байгаа гэдэг үүднээс давхар хяналт тавих, эсвэл аль аль нь хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй байх жишээтэй байна.

Жишээ нь: Усны тухай хуулийн 28.4, 28.6, 29.1-д заалтаар ус болон усан орчин ашиглуулах дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах үүргийг Сав газрын захиргаа, аймгийн БОАЖГ, сумын Засаг даргад өгсөн нь усны тухай хуулийн хэрэгжилт, бодлого, хяналт нь орон нутгийн түвшинд нэгдсэн байдлаар хэрэгжиж чадахгүй байх үндэслэл болж байна.

Үүнээс үзэхэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчин байгаа боловч хяналтын тогтолцоо нь өөр өөр агентлагуудад хуваагдсан байдалтай байна.

Тухайлбал:

- БОАЖГ-аас байгаль орчныг хамгаалахтай холбоотой гарсан зөрчилд албан тоот өгөхөөс бусдаар хариуцлага тооцож чадахгүй байна.
- Рашаан, ус ашиглагч байгууллагууд 2014-2016 онд Усны тухай хууль зөрчсөн байхад МХГ-аас сүүлийн 3 жилд ус ашиглалттай холбоотой хяналт тавиагүй байна.

Зорилт 4.2 2014-2015 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд дотоод нэгжүүдээс хяналтыг хэрэгжүүлсэн боловч хангалтгүй байна.

Байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоод хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх БОАЖГ, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, аймгийн МХГ, ИББЦГХЗ, аймгийн Татварын хэлтэс хэрэгжүүлж ирсэн байна.

2014-2015 онд агентлагуудын ажлын уялдаа холбоо сул, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн ногдуулж төвлөрүүлж чаддаггүй, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг зөрчсөн зөрчилд тэр бүр хариуцлага тооцоогүй байна.

Дээрх байдлыг зохицуулахын тулд БОАЖГ, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, ИББЦГХЗ, УЦУОША хамтран ажиллах санамж бичгийг 2016.05.19-ний өдөр байгуулан ажиллажээ.

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар 2015 онд хийгдсэн уул, уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2016 оны 7-р сард аймгийн Засаг даргын 507 тоот захирамжаар тус байгууллагууд хамтран уул уурхайн нөхөн сэргээлтийн компаниудад ус ашиглалттай холбоотой шалгалт хийж, 2014, 2015 онуудын ус ашиглалтыг нөхөн тооцож 96,6 сая төгрөгийн ногдуулалт, 23,1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Аудитаар нийт 27,6 сая төгрөгийн зөрчил илэрч, 19,6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоон, 8,0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, илэрсэн зөрчилд Байгаль орчны хяналтын улсын байцаагч 5,4 сая төгрөгийн торгууль ногдуулав.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Аймаг, сумын ИТХ-аас байгаль хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой тогтоол баталсан боловч түүний хэрэгжилтэд хяналт тавиагүй, аймаг, сумын Засаг дарга ус, рашааны болон ердийн ашигт малтмалын үнэ тогтоосон тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

2. Өлзийт, Жаргалант, Баян-Овоо, Заг, Галуут, Бөмбөгөр зэрэг сумууд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.1, ашигт малтмалын тухай хуулийн 7.3 дахь заалтыг зөрчиж нөхөн сэргээлт нэрээр алт олборлох үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ зохион байгуулсаар байна.

3. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөснөөс 2014 онд 100,6 сая, 2015 онд 83,8 сая төгрөгөөр дутуу орсон нь уул уурхайн компаниуд уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа бүрэн явуулаагүйгээс шалтгаалжээ.

4. Ан, агнуурын нөөц ашигласны орлого төлөвлөснөөс 2014 онд 71,8 сая, 2015 онд 383,3 сая төгрөгөөр илүү орсон нь ан, агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой бус байгааг харуулж байна.

5.

6. Баянцагаан, Заг, Баян-Овоо, Жинст сумд ан, агнуурын нөөц ашигласны орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө хуваарилж зарцуулаагүй байна.

7. Аймгийн МХГазар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26.1, аймгийн БОАЖГ Усны тухай хуулийн 18.1.1 дэх заалтын дагуу хууль хэрэгжүүлэх албан бичиг өгч, шаардлага хүргүүлж байгаа боловч сумдын Засаг дарга нар Байгаль

орчныг хамгаалах тухай болон Усны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

8. Аймгийн Татварын хэлтэс нь усны нөөц ашигласны төлбөрийн тайланг хүлээн авахдаа Татварын ерөнхий хуулийн 29.1.8. “татвар ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх, татвар хураахдаа Монгол Улсын татварын болон бусад хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх” гэсэн заалтын дагуу татварын ногдуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт тавиагүй байна.

9. Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх ёстой төрийн байгууллагуудын хяналт шалгалт нь давхардах, эсвэл аль аль нь хяналт тавихгүй орхигдох тохиолдол байгаа ба орон нутгийн түвшинд хууль нэгдсэн байдлаар хэрэгжиж чадахгүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ё.СУГАРРАГЧАА

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 дэх “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Амьтны тухай хуулийн 26.2. “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.1, 16.2.2 –т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллах.

2. Аймгийн ИТХ-ын 2013 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Рашааны үнэ тогтоох тухай” тогтоолыг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлэх.

3. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг холбогдох төрийн байгууллагын тайлан мэдээ, гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөж аймгийн ИТХ-д өргөн барих.

Сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга нарт

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.2.1-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж нөхөн сэргээлт хийх нэрээр олборлолт явуулж байгааг зогсоох.

2. Усны тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасны дагуу нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуваарилж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зарцуулж байх.

4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг татварын тайлан мэдээнд зөв ангилан тайлагнаж байх.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт

1. Усны тухай хуулийн 18.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж, сумдын усны хэрэглээг тооцож, мөн хуулийн 27.1, 29.1 дэх заалтын дагуу зөвшөөрөл олгож, гэрээний үндсэн дээр ус ашиглуулах.
2. Амьтны тухай хуулийн 5.8.1, 5.8.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Бөөнцагаан-Орог нуурын сав газарт

1. Усны тухай хуулийн 17.1.10 дахь заалтын дагуу сав газрын хэмжээнд ашиглаж байгаа ус, рашааны ашиглалтад хяналт тавьж гарсан зөрчилд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож, мөн хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргаж байх.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт

1. Байгалийн нөөцийн ашиглалтад /ус, рашаан/ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26.1-д заасны дагуу хяналт тавих, хариуцлага тооцох.
2. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016.04.18-ны 4/110 тоот албан бичгийн хэрэгжилтийг тооцох.

Аймгийн Татварын хэлтэст

1. “Чандмань-Баянхонгор” ХК-ийн 2014, 2015 оны усны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтад хяналт шалгалт хийх, 2016 оны ногдуулалтыг усны дүгнэлтийн дагуу тооцож, Татварын ерөнхий хуулийн 29.1.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг татварын тайлан мэдээнд зөв ангилан тайлагнаж байх.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг заалт нэг бүрээр гарган 2016 оны 12-р сарын 01-ний дотор албан тоотоор ирүүлнэ үү.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ё.СУГАРРАГЧАА

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
<http://www.bayankhongor.gov.mn>
Утас 70-44-22-73

2016-10-06 № 7/793
танай 2016-10-05-ны № 148 Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн
хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлантай
танилцлаа.

Ямар нэгэн саналгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ИХБАЯР

а/а Б.Монгол-д
Амжилт бориул
болон хувилж авал!

D:\2016 on\toot A5-2016 on\docx



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯНХОНГОР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 21

Номгон

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор тзвшөөрөх бүрэн эрх"-ийн 11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилт"-нд хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. "Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилт"-нд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Нийцлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Мөнхбат, аудитор М.Алтантуяа нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Е. СУГАРРАГЧАА

516020

Баянхонгор аймгийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын 2016 оны 10 дугаар сарын
05 -ны өдрийн 21 дугаар тушаалын хавсралт

Байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн
нийцлийн аудитын төлбөр зөрчлийн жагсаалт

мян.төг					
№	Байгууллагын нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн	Албан шаардлага	Акт
1	Өлзийт сумын ЗДТГ	"Бурам арвижих" ХХК-ийн ус ашигласны төлбөрийн орлогыг ЗДТГ-ын өөрийн орлогын дансанд төвлөрүүлсэн.	2000,0		2000,0
2	Өлзийт сумын ЗДТГ	"Бурам арвижих" ХХК-ийн хандивын орлогыг ЗДТГ-ын няравт бэлнээр хүлээн авч, төсөвт тушаагаагүй.	15000,0		15000,0
3	Өлзийт сумын 4-р багийн Засаг дарга	Байгаль хамгаалах зардлын санхүүжилтээр хийгдсэн булгийн эх хаших ажил хийгдээгүй.	6000,0	6000,0	
4	Баян-Өндөр сумын Засаг дарга	Байгаль хамгаалах зардлын санхүүжилтээр хийгдсэн булгийн эх хашсан хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй.	2000,0	2000,0	
4	Хүрээмарал сумын Засаг дарга	"Хонгор хангай эрдэнэс" ХХК-ийн ус ашигласны төлбөрийн орлогыг сумын түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогоор тайлагнан, сумын төсөвт зарцуулсан.	410,9		410,9
5	Шинэжинст сумын Засаг дарга	Уул уурхайн компаниудын ус ашигласны төлбөрийн орлогыг сумын түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогоор тайлагнан, сумын төсөвт зарцуулсан.	2230,0		2230,0
Нийт			27640,9	8000,0	19640,9

___oO___